**ХЭНТИЙ АЙМГИЙН**
**БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2026 оны 08 сарын 10 өдөр Дугаар А/124 Биндэр сум

Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд
дундаа хамтран өмчилсөн газрыг гэр
бүлийн нэг гишүүнд шилжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалтууд, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран газар өмчилсөн иргэдийн эрх шилжүүлэх гэрээ, хэлцлийг харгалзан газрыг 1 дүгээр хавсралтад дурдсан 1 иргэнд 1058 м2 газрыг үнэ төлбөргүй шилжүүлэн өмчлүүлсүгэй.

2.Гэр бүлийн нэг гишүүний өмчилж авсан газарт энэхүү захирамжийг үндэслэн газрын кадастр хийх, газар өмчлөгчид хүлээлгэн өгөх, хилийн заагийг газар дээр нь тэмдэгжүүлэх, улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулж, газар өмчлөгчийг хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллахыг сумын газрын даамал (Н.Болор-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2007 оны А/30 тоот захирамжийн 2 дахь хэсгийг хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4.Газраа шилжүүлсэн иргэдэд хууль тогтоомжид заасны дагуу газар үнэгүй өмчлөх эрхээ эдлэх боломжтой болохыг зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН

Сумын Засаг даргын 2026 оны 08 дугаар сарын
10-ны өдрийн А/124 тоот захирамжийн хавсралт

| № | Өмчлөх эрхээ шилжүүлэн авч байгаа иргэний | | | | Хамтран өмчлөлөөс хасуулж байгаа иргэний | | | | Захирамжийн | | | | Өмнөх газрын | | Одоо газрын | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Ургийн овог | Овог | Нэр | Регистрийн дугаар | Ургийн овог | Овог | Нэр | Регистрийн дугаар | Огноо | Дугаар | Хавсралтын дугаар | Холбогдох хэсгийн дугаар | Хуучин нэгж талбарын дугаар | Хэмжээ /м2/ | Байршил, хаяг | Шинэ нэгж талбарын дугаар | Хэмжээ /м2/ |
| 1 | Тэгс | Нямаа | Энхцэцэг | СУ40041373 | Халибан | Батбаяр | Гэрэлханд | СБ95011224 | 200704,20 | 30 | 1 | 2 | 220700827 | 840 | Ягнуй-2 216 | 2310000869 | 1058 |
| | | | | | Халибан | Батбаяр | Гэрэлчимэг | СБ92111708 | | | | | | | | | |